

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2023/13/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2023 он	Дархан Уул аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 7037-3089, 9902-3869 Цахим хаяг: munkhbayrsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 9903-6806 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 7037-3089 Цахим хаяг: battsetsgs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Си Эс Ай Аудит ХХК Захирал: М.Сэвжидмаа Утас: 70001981 Цахим хаяг: sevjidmaa@csiaudit.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон	8
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон	9
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
3.1 Албан шаардлага	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12
4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	13
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХААТҮДТ	Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлчилгээний газар



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ХӨДӨӨ, АЖ АХУЙН ТЕХНИК
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДУНДЫН ТӨВ” ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Б.БЭЭЖИН ТАНАА

2023.03.15 № 169
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх-үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв” ОНӨААТҮГ-ыг төмс, хүнсний ногооны тариалалт, арчлалт, хураалтын ажлыг технологийн дагуу, хугацаанд нь чанартай гүйцэтгэж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтворжуулан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12-р сарын 16-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор байгуулж, Улсын бүртгэлд 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр бүртгүүлж, гэрчилгээ авсан байна. Байгууллагын даргаар Б.Бээжинг Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн 01-Б/05 тоот захирамжаар томилсон байна.

Аудитын гол асуудал

Хүнс хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/238 дугаар тушаалыг үндэслэн “Трактор, хөдөө аж ахуйн техник худалдах, худалдан авах” БэлТТ-221/108/-09 тоот гэрээг 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдөр байгуулж, 195,472 еврогийн 8 иж бүрэн техник тоног төхөөрөмжийг хүлээлгэн авсан боловч холбогдох баримт бичгийн бүрдэлгүй шалтгаанаар бүртгэл тайланд тусгаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

009020268

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

"Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв" ОНӨААТҮГ-ын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 70 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		1,650,654.00
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НД-н шимтгэлийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал		
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/ тооцоо		
1.1.10	Санхүүгийн түрээсийн авлага		
	Эргэлтийн хөрөнгийн дүн		1,650,654.00
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө		357,690,893.33
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.9	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		357,690,893.33
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		359,341,547.33
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		6,795,602.70
2.1.1.3	Татварын өглөг		2,368,506.41
2.1.1.4	НДШ-ийн өглөг		8,306,967.26
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүгийн өглөг		
	Богино хугацаат өр төлбөрийн дүн		17,471,076.37
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
	Өр төлбөрийн нийт дүн		17,471,076.37
2.2	Эзэмшигчдийн өмч		
2.2.1	Өмч: а) төрийн		363,182,600.00
2.2.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.4	Хуримтлагдсан ашиг (алдагдал)		(21,312,129.04)
	Эзэмшигчдийн өмчийн дүн		341,870,470.96
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		359,341,547.33

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		39,114,640.00
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)		39,114,640.00
5	Хүүгийн орлого		
6	Бусад орлого		
7	Ерөнхий ба удирдлагын зардал		60,426,769.04
8	Санхүүгийн зардал		
9	Бусад зардал		
10	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
11	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		(21,312,129.04)
12	Орлогын татварын зардал / (буцаалт)		
13	Татварын дараах ашиг (алдагдал)		(21,312,129.04)
14	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(21,312,129.04)
15	Бусад дэлгэрэнгүй орлого		
16	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
17	Орлогын нийт дүн		(21,312,129.04)
18	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Дахин үнэлгээний нэмэгдэл	Эрсдэлийн сан	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл					
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2021 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл					
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал				(21,312,129.04)	(21,312,129.04)
Өмчид гарсан өөрчлөлт	363,182,600.00				363,182,600.00
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2022 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	363,182,600.00			(21,312,129.04)	341,870,470.96

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		46,614,640.00
1.1.1	Бараа Борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		39,114,640.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан орлого		
1.1.4	Бусад мөнгөн орлого		7,500,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)		44,963,986.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн		20,277,955.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн		
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хэрэгсэл, сэлбэг хэрэгсэлд төлсөн		13,543,081.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага		11,142,950.00
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		1,650,654.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.2	Хүүний орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.2	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Төлсөн ногдол ашиг		
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		1,650,654.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,650,654.00

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого		39,114,640.00	(39,114,640.00)	
1.1	Түрээсийн орлого		39,114,640.00	(39,114,640.00)	
2	Үйл ажиллагааны зардал		60,426,769.04	(60,426,769.04)	
2.1.	Цалингийн зардал		37,759,031.37	(37,759,031.37)	
2.1.1	Цалин хөлс нэмэгдэл урамшуулал		33,267,869.05	(33,267,869.05)	
2.1.3	ААН-ээс төлсөн НДШ		4,491,162.32	(4,491,162.32)	
2.	Бараа үйлчилгээний бусад зардал		21,025,637.67	(21,025,637.67)	
2.1	Бичиг хэрэг		75,600.00	(75,600.00)	
2.2	Тээвэр шатахуун		9,484,821.00	(9,484,821.00)	
2.3	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс		5,507,260.00	(5,507,260.00)	
2.4	Шуудан холбоо интернетийн төлбөр		466,250.00	(466,250.00)	
2.5	Элэгдлийн зардал		5,491,706.67	(5,491,706.67)	
3	Төлбөр хураамж, үйлчилгээний зардал		1,642,100.00	(1,642,100.00)	
3.1	Аудитын үйлчилгээний хөлс		330,000.00	(330,000.00)	
3.2	Мэдээлэл технологийн зардал		1,283,500.00	(1,283,500.00)	
3.3	Банкны үйлчилгээний хураамж		28,600.00	(28,600.00)	
4	Үйл ажиллагааны ашиг		(21,312,129.04)	(21,312,129.04)	
5	Татвар төлсний дараах ашиг		(21,312,129.04)	(21,312,129.04)	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 301.7 сая төгрөгийн алдаа илэрснээс, аудитын явцад алдааг бүрэн залруулав.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Дархан Уул аймгийн засаг даргын 2022 оны 12 сарын 30-ны 01/А/371 тоот захирамжаар 288.7 сая төгрөгийн лууван хураагч тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгснийг данс бүртгэлд тусгаагүй байна.
- Орлогын дэлгэрэнгүй тайланд буцаж орж ирсэн 7.5 сая төгрөгийн гүйлгээг орлогоор бүртгэсэн байна
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 5.5 сая төгрөг нөхөж тооцов.

Аудитаар нийт 4 зөрчил илэрснээс, 2 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Тус байгууллага нь санхүүгийн төлөвлөгөө техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулаагүй байна

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3-т *"Төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох"*, 20 дугаар зүйлийн 20.1.3-д *"Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн төлөвлөгөө техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж байх. алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Илрүүлэлт 2: Тус байгууллагын түрээсийн гэрээ нь хууль эрх зүйн актын хувьд хангалтгүй байна. Жишээ нь түрээсийн гэрээнд, жолоочийн цалин, шатахууны зардал болон 1 га-д зарцуулах технологийн зардлыг бүрэн тооцох, эвдрэл гэмтэл гарвал хэн хариуцах, төлбөр тооцоо бүрэн төлөгдөөгүй гэрээнээс алданги тооцох, тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн акт үйлдэх, түрээсийн хугацаа гэрээнээс өмнө цуцлагдах талаар, мөн хуулийн заалтуудыг бүрэн тусгаж өгөөгүй байна.

Энэ нь Иргэний хуулийн 287 дугаар зүйлийн 287.1-т *"Эд хөрөнгө хөлслөх гэрээгээр хөлслүүлэгч нь хөлслөгчийн эзэмшил, ашиглалтад тодорхой эд хөрөнгийг түр хугацаагаар шилжүүлэх, хөлслөгч нь эд хөрөнгө ашигласны хөлсийг төлөх үүргийг тус тус хүлээнэ"*. 318 дугаар зүйлийн 318.1-т *Түрээсийн гэрээ*

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн гэрээг дахин шинэчлэн хууль эрх зүйн актад нийцүүлэн байгууллагын эрх ашгийг тодорхой тусгаж өгч, холбогдох зардлыг тооцож, түрээсийн үнэ тогтоох, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт1: Түрээсийн шатахууныг мото/цагаар тооцож зарцуулалтыг гаргалгүй шууд зардалд бичсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дүгээр тушаалын 3 хавсралтаар баталсан Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд "2.5.1-т "Автомашины шатахуун зарцуулалтын нормыг гүйлтээр тооцох боломжгүй технологийн тээвэрлэлт гүйцэтгэх автомашин, тусгай төхөөрөмж бүхий автомашины тусгай төхөөрөмж ажиллуулахад олгох шатахуун, автомашиныг хүйтний улиралд халаах /гүйлт 0/ зэрэг нөхцөлд шатахуун зарцуулалтыг хөдөлгүүрийн асаалтын горимын нэг цагт зарцуулагдах шатахуунаар буюу 1 мото/цагаар тооцож олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, мото/цагаар тооцож зарцуулалтыг гаргах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт2: Тус байгууллага нь Хөдөлмөрийн дотоод журам батлаагүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-д "Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөдөлмөрийн дотоод журам батлан хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дархан Уул аймгийн засаг даргын 2022 оны 12 сарын 30-ны 01/А/371 тоот захирамжаар 288.6 сая төгрөгийн лууван хураагч тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгснийг данс бүртгэлд тусгаагүй байна.	1	288,750.0	1	288,750.0			1	288,750.0				
2	Орлогын дэлгэрэнгүй тайланд буцаж орж ирсэн 7.5 сая төгрөгийн гүйлгээг орлогоор бүртгэсэн байна	1	7,500.0			1	7,500.0	1	7,500.0				
3	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 5.5 сая төгрөг нөхөж тооцов.	1	5,491.7	1	5,491.7			1	5,491.7				
	Дүн	3	301,741.7	2	294,241.7	1	7,500.0	3	301,741.7				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Үүнээс											
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Тус байгууллага нь санхүүгийн төлөвлөгөө техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулаагүй байна	1				1	-						
2	Тус байгууллагын түрээсийн гэрээ нь хууль эрх зүйн актын хувьд хангалтгүй байна. Жишээ нь түрээсийн гэрээнд, жолооч цалин, шатахууны зардал болон Iga зарцуулах зардлыг бүрэн тооцох, эвдрэл гэмтэл гарвал хэн хариуцах, төлбөр тооцоо бүрэн төлөгдөөгүй бол алданги тооцох, Тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн акт үйлдэх, түрээсийн хугацаа гэрээнээс өмнө цуцлагдах талаар, мөн хуулийн заалтуудыг бүрэн тусгаж өгөх, шатахууныг хэн төлөх тусгах нь гаргах	1				1							

**"Хөдөө аж ахуйн техник үйлчилгээний дундын төв" ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан**

	эрсдэлийг бүрэн тусгаж өгөөгүй байна												
3	Түрээсийн шатахууныг мото/ цагаар тооцож зарцуулалтыг гаргалгүй шууд зардалд бичсэн байна.	1						1					
4	Тус байгууллага нь Хөдөлмөрийн дотоод журам батлаагүй байна.	1						1					
	Дүн	4				2		2					

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 91 мэдээллийг хугацаанд байршуулж, 58 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-					1	-
	Нийт дүн	1	-					1	-